



**ТОГТВОРТОЙ
УУЛ УУРХАЙН
ТӨЛӨӨ**



МОНГОЛЫН УУЛ УУРХАЙН
ҮНДЭСНИЙ АССОЦИАЦИ

**ТУУТ (TSM) СТАНДАРТЫН
БАТАЛГААЖУУЛАЛТЫН
ПРОТОКОЛ**



ТУУТ (TSM) СТАНДАРТЫН БАТАЛГААЖУУЛАЛТЫН ПРОТОКОЛ

Олон улсын хөдөлмөрийн байгууллагын (ОУХБ) Албадан хөдөлмөр, Хөдөлмөр эрхлэх доод нас, Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрийн тухай 29, 138 болон 182 дугаар конвенцод заасан хүүхдийн болон албадан хөдөлмөрөөс сэргийлэх арга хэрэгсэл.

Энэхүү баталгаажуулалтын протокол нь Олон улсын хөдөлмөрийн байгууллага (ОУХБ)-аас гаргасан 29, 138, 182 дугаар конвенци буюу Албадан хөдөлмөр, Хөдөлмөр эрхлэх доод нас, Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрийн тухай ковенцид тодорхойлогдсон хүүхдийн болон албадан хөдөлмөрөөс сэргийлэх зааварчилгаа юм.

Зорилго

Энэхүү баталгаажуулалтын протоколын зорилго нь хүүхдийн хөдөлмөр, албадан хөдөлмөрөөс сэргийлэхтэй холбоотой баталгаажуулалтын шаардлагуудыг хангахад гишүүн компаниудад чиглэл өгөх явдал юм. Баталгаажуулалтын протокол нь ТУУТ (TSM) стандартад хамрагдаж буй уурхайд ОУХБ-ын зүгээс тодорхойлсон хүүхдийн болон албадан хөдөлмөр байхгүй болохыг баталгаажуулах үйл явц нь тогтсон болохыг үнэлэн баталгаажуулахад хэрэглэх ерөнхий арга хандлагыг тодорхойлдог.

Менежментийн тогтолцоонд хийгдэж буй аливаа үнэлгээний нэгэн адил системийн үзүүлэлтийн хэрэгжилтийн түвшин, менежментийн үйл явц, үйл ажиллагааны чанарыг үнэлэхэд мэргэжлийн дүгнэлт, шинжилгээ шаардлагатай байдаг. Тиймээс энэхүү протоколыг хэрэгжүүлэхэд аудит, системийн үнэлгээний чиглэлээр мэргэшсэн байх, хөдөлмөр эрхлэлтийн нөхцөл байдал, үүнд хамаарах эрх зүйн орчин, шаардлагуудын талаарх практик мэдлэг, туршлага шаардагдана. Энэхүү протокол нь хүүхдийн болон албадан хөдөлмөр ашиглагдахгүй буй эсэхийг баталгаажуулах үзүүлэлтийг гарган өгсөн ба ТУУТ (TSM) стандартын Баталгаажуулалтын үйлчилгээ үзүүлэгчийн Ажлын даалгавартай уялдуулан ашиглах ёстой. Гэвч энэ нь дангаараа тухайн компани дахь хөдөлмөр эрхлэлтийн практикийн үр дүнтэй байдлыг баталгаа дангаар болохгүй.

Хүүхдийн болон албадан хөдөлмөрт хамаарах ТУУТ (TSM) стандартын үүрэг амлалт

ТУУТ (TSM) стандартын зарчимд заасан буй гол зорилтын хүрээнд Канадын Уул уурхайн ассоциацийн гишүүн байгууллагууд нь ОУХБ-ын 29, 138 болон 182 дугаар конвенц дээр заагдсан ажиллагсдын эрхийг хүндэтгэх, албадан болон хүүхдийн хөдөлмөрийг ашиглахгүй байх чиглэлд хүчин чармайлт гарган ажилладаг.

ОУХБ-ын Албадан хөдөлмөрийн тухай 29 дүгээр конвенцын гол бүрэлдэхүүн хэсгүүд

[ОУХБ 29, Албадан хөдөлмөрийн тухай конвенц](#)

Энэхүү конвенц нь ямар нэг торгууль шийтгэл ногдуулахаар заналхийлж аливаа иргэнээс өөрийгөө сайн дураар санал болгоогүй байхад шаардах аливаа ажил, үйлчилгээ хэмээн тодорхойлдог. Конвенц нь албадан хөдөлмөрийн төрлөөс заавал гүйцэтгэх цэргийн алба, иргэний үүрэг хариуцлага, олон нийтэд үйлчлэх, тодорхой нөхцөлд гүйцэтгэх ялтны хөдөлмөр болон онцгой байдлын үеийн ажил үйлчилгээ зэргийг хассан байдаг. 29 дүгээр конвенцын 4 дүгээр зүйлд хувь хүн, аж ахуйн нэгж болон эвсэл холбоод өөрт өгөөж хүртэх зорилгоор албадан хөдөлмөр ашиглахыг тусгайлан хориглодог. Бусад зүйл заалтууд нь төр засгийн зүгээс албадан хөдөлмөр ашиглахтай асуудлыг хамардаг.

ОУХБ-ын Хүүхдийн хөдөлмөрийн талаарх 138 болон 182 дугаар конвенцын бүрэлдэхүүн хэсгүүд

ОУХБ-ын Хөдөлмөрийн насны доод хязгаарын тухай 138 дугаар конвенц

Энэхүү конвенц нь хүүхдийн хөдөлмөр эрхлэх доод насыг тогтоосон байдаг. Тус конвенцоор хөдөлмөр эрхлэх насны доод хязгаарыг 15 байхаар тогтоож, улмаар үүний үндэслэлийг өсвөр настны эрүүл мэнд, аюулгүй байдал, ёс суртахуунд сөргөөр нөлөөлж болох ажил хэмээн үздэг. Өсвөр настны эрүүл мэнд, аюулгүй байдал, ёс суртахуунд сөргөөр нөлөөлж болох ажлын төрлийг дотоодын хууль журамд эсвэл эрх бүхий байгууллагын зүгээс тогтоосон байх ёстой. 138 дугаар конвенцод 15-аас доош насны хүнийг зарим тохиолдолд ажиллуулж болохоор заасан ч энэ нь уул уурхайн салбарт хамаарахгүй. ОУХБ-ын конвенцууд нь хүүхдийн хөдөлмөр эрхлэлт бүхий газарт тухайн асуудлыг бууруулах арга хэмжээг заасан ба үүнд дараах багтдаг:

Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрээс хүүхдийг чөлөөлөх, нөхөн сэргээх болон нийгэмшүүлэх

Үнэ төлбөргүй суурь боловсрол олгох, боломжтой, зохистой тохиолдолд мэргэжлийн сургалтад хамруулах.

ОУХБ 182, Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрийн тухай конвенц

Энэхүү конвенц нь “тэвчишгүй хэлбэр” хэмээн тооцогдох хүүхдийн хөдөлмөрийн тодорхой төрлүүдийг тодорхойлон, эдгээр хэлбэрийн ажилд хүүхдийг ажиллуулахаас сэргийлэх арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг шаарддаг. Дээр дурдсан тэвчишгүй хэлбэрүүдийн 2 нь уул уурхайн салбарт хамаардаг:

- боолчлолын бүх хэлбэр болон хүүхдийг худалдах, дамжуулан худалдах, өрийн төлөөс, хамжлагын албат болгох, хүчээр буюу албадан хөдөлмөрлүүлэх, түүний дотор зэвсэгт мөргөлдөөнд ашиглах зорилгоор хүчээр буюу албадан оролцуулах зэрэг боолчлолтой төстэй дараах үйл ажиллагаа,
- ажлын шинж чанар, түүнийг гүйцэтгэх нөхцөл нь хүүхдийн эрүүл мэнд, аюулгүй байдал, ёс суртахуунд хор нөлөө үзүүлэх ажил.

Хүүхдийн хөдөлмөрийн хувьд 182 дугаар конвенц нь хүүхдийн эрүүл мэнд, аюулгүй байдал болон ёс суртахуунд сөрөг нөлөө үзүүлэх ажлыг дотоодын хууль тогтоомждоо тусгаж байхыг шаарддаг.

Үүрэг амлалтыг баталгаажуулах

Албадан болон хүүхдийн хөдөлмөр нь ТУУТ (TSM) стандартын бусад асуудлуудын нэгэн адил байнгын сайжруулалт гаргах зорилгоор удирдах зүйл эсвэл менежментийн тогтолцоонд төвлөрсөн стандартын протоколыг гаргах замаар шийдэх асуудал бус харин гишүүн компаниуд болон тэдний ханган нийлүүлэлтийн сүлжээнд сэргийлэх, эцэслэх шаардлага бүхий асуудлууд юм. Энэ тохиолдолд баримтлах үндсэн хандлага нь компаниудын өмнөө тавьсан зорилго, авсан үүрэг амлалт нь ТУУТ (TSM) стандартын чиглүүлэх зарчмуудад заасанчлан хүүхдийн болон албадан хөдөлмөр үл ашиглах явдал байх ба үүнийг даган мөрдөж, даган мөрдөж буйгаа олон нийтэд нээлттэйгээр тайлагнаж байхад чиглэдэг. Энэхүү шаардлагыг хангахын тулд Баталгаажуулалтын үйлчилгээ үзүүлэгчдэд нь Канадын Уул уурхайн ассоциацийн гишүүд дээр хийж буй өөрийн баталгаажуулалтын ажилд доорх хүүхдийн болон албадан хөдөлмөрийн хэсэгт жагсаасан буй асуултуудыг багтаан уялдуулж байхыг чиглэл болгодог.

ҮЗҮҮЛЭЛТ 1: АЛБАДАН ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТЭЭС СЭРГИЙЛЭХ

Шаардлагууд

Гишүүн компаниуд нь албадан хөдөлмөрийг ашиглахгүй буйг баталгаажуулахаар тухайн үйл ажиллагаа явуулж буй улсад хамаарах эрсдэлийн хэмжээнд нийцэх арга хэмжээ, процессийг бүрдүүлсэн байх.

Баталгаажуулалтын зааварчилгаа:

Ярилцлага эсвэл баримт бичгийн судалгаа хийх замаар доорх зүйлсийг тодорхойлох:

1. Албадан хөдөлмөр, үүнд ялтны хөдөлмөр, өрөөр барьцаалсан хөдөлмөр, гэрээт боолын хөдөлмөр ашиглахгүй байх зорилгоор тухайн улсын хамаарах эрсдлийг тооцсон процессийг бүрдүүлсэн байх.
2. Албадан хөдөлмөрийн эрсдэл өндөр бол ханган нийлүүлэлтийн сүлжээ болон хөдөлмөр зуучлалын харилцаанд хяналт тавьж, хүн худалдаалах болон албадан хөдөлмөр холбогдож буй эсэхийг хянах үйл явцыг бүрдүүлсэн байх.

ҮЗҮҮЛЭЛТ 2: ХҮҮХДИЙН ХӨДӨЛМӨРӨӨС СЭРГИЙЛЭХ

Шаардлага

Гишүүн компаниуд нь дотоодын хууль тогтоомжид заасан 18 хүртэлх насны хүүхэд эрхлэх тохиолдолд эрүүл мэнд, аюулгүй байдал, ёс суртахуунд сөрөг нөлөө үзүүлэх ажилд хүүхэд ажиллуулах, 15-аас доош насны хүмүүсийг ажиллуулж байх эрсдэлтэй нийцэх хэмжээнд эдгээр наснаас доош хүмүүсийг ажиллуулахгүй байхыг баталгаажуулах үйл явцыг бүрдүүлсэн байна.

Баталгаажуулалтын зааварчилгаа:

Ярилцлага эсвэл баримт бичгийн судалгаа хийх замаар доорх зүйлсийг тодорхойлох:

1. Дотоодын хууль, журмын дагуу 18-аас доош насны хүүхдийг эрүүл мэнд, аюулгүй байдал, ёс суртахуунд нь сөргөөр нөлөөлж болзошгүй ажилд оролцуулахгүй байх, мөн 15-аас доош насны хүүхдийг огт ажиллуулахгүй байх нөхцөлийг бүрдүүлсэн тухайн улсын эрсдлийг тооцсон процесстэй байна.
2. Хамаарах улсын эрсдэлээс хамааран 15-аас доош насны хүүхдийг ажиллуулахгүй байхыг эрсдэлийн түвшинтэй уялдуулан баталгаажуулж байх үйл явц бүрэлдсэн байх.

ХАВСРАЛТ 1: ТҮГЭЭМЭЛ АСУУЛТУУД

1. ТУУТ (TSM) стандарт нь албадан хөдөлмөрийг хэрхэн тодорхойлдог вэ?

ТУУТ (TSM) стандарт нь албадан хөдөлмөрийг тодорхойлохдоо ОУХБ-ын Албадан хөдөлмөрийн тухай 29 дүгээр конвенцыг баримталдаг ба аливаа хүн өөрөө сайн дурын үндсэн дээр гүйцэтгэхийг санал болгоогүй байхад нь ямар нэг шийтгэл хүлээлгэхээр айлган сүрдүүлж хийж гүйцэтгүүлсэн бүх ажил буюу үйлчилгээ хэмээн тодорхойлдог. Тус конвенц нь заавал хаах хугацаат цэргийн алба; иргэний ердийн үүрэг; шүүхээр ял шийтгэсэн; онцгой байдлын нөхцөлд хийх ажлыг тодорхойлолтод хамруулаагүй. ОУХБ-ын 29 дүгээр конвенцын 4 дүгээр зүйл нь хувь хүн, аж ахуйн нэгж, байгууллага, холбоод өгөөж хүртэх зорилгоор албадан хөдөлмөр ашиглахыг хориглодог. Үлдэх зүйл заалтууд нь төрийн зүгээс албадан хөдөлмөр ашиглах явдлыг зохицуулсан.

2. Албадан хөдөлмөр ашиглахаас сэргийлэхийн тулд бүрдүүлсэн байх үйл явцуудын ямар жишээ байж болох вэ?

Албадан хөдөлмөр эрхлүүлэхээс сэргийлэх түгээмэл үйл явцуудын жишээнд дараах багтаж болно:

- Ажлын байр болон уурхай дээрх амьдрах орчноос шилжилт хөдөлгөөн хийх эрхийг үндэслэлгүйгээр хязгаарлахаас сэргийлэх,
- Ажилтны хувийн баримт бичгийн эх хувийг, жишээ нь иргэний баримт бичгийг хураан авахаас сэргийлэх,
- Ажилтнуудаас урьдчилгаа дэнчин, ажилд авсны төлбөр, тоног төхөөрөмжийн урьдчилгаа зэрэг ямар нэгэн хэлбэрийг барьцааг шууд эсвэл хөдөлмөр зуучлалын байгууллагаар дамжуулан авахыг хориглох,
- Үндэслэл бүхий мэдэгдэл өгснөөр эсвэл хамаарах хуульд заасны дагуу ажилтан өөрийн хөдөлмөр эрхлэлтийг цуцлахад саад тотгор учруулахаас сэргийлэх.

Ийм төрлийн үйл явц тогтсон буй эсэхийг тогтоох нотолгоог олж тогтооход тухайн баталгаажуулалт хийгдэж буй улсад албадан хөдөлмөрийн асуудлаарх хамаарах эрсдэлийн түвшнийг харах нь чухал ач холбогдолтой. Зарим улсад албадан хөдөлмөрлүүлэх эрсдэл нь бусдаас илүү өндөр байх тул энэхүү асуудал нь эрсдэл бус хэмээн тооцогдох бусад улстай харьцуулбал илүү нарийн үйл явцыг шаардана.

3. ТУУТ (TSM) стандарт нь хүүхдийн хөдөлмөрийг хэрхэн тодорхойлдог вэ?

ТУУТ (TSM) стандарт нь ОУХБ-ын зүгээс гаргасан Хөдөлмөрийн насны доод хязгаарын тухай 138 дугаар конвенцын тодорхойлолтыг баримталдаг. Тухайн конвенц нь хүүхдийн хөдөлмөрийн насны доод хязгаарт тавигдах шаардлагуудыг тогтоодог. Энэхүү конвенцоор хөдөлмөр эрхэлж болох доод насыг 15 байхаар зааж, улмаар өсвөр үеийнхний эрүүл мэнд, аюулгүй байдал, ёс суртахуунд сөрөг нөлөө үзүүлж болзошгүй ажлын онцлог

болон нөхцөл байдлаас шалтгаалж зарим ажил эрхлэх доод насыг 18 байхаар заасан. Эрүүл мэнд, аюулгүй байдал, ёс суртахуунд сөрөг нөлөө үзүүлж болзошгүй ажлын төрлийн үндэсний хууль тогтоомж эсвэл эрх бүхий байгууллагын гаргах журмаар заан өгөхөөр зохицуулсан.138 дугаар конвенц дээр зарим нөхцөлд 15-аас доош насны хүүхэд хөдөлмөр эрхэлж болох заалт буй ч энэ нь уул уурхайн салбарт хамаарахгүй.

ТУУТ (TSM) стандарт нь хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэр” хэмээн тооцогддог 4 төрлийг тодорхойлж, энэ төрлийн хөдөлмөрт эрхлэлтэд хүүхдүүдийг хамруулахгүй байхаас сэргийлэх арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг үүрэг болгосон ОУХБ-ын Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрийн тухай 182 дугаар конвенцыг мөн даган мөрддөг. Тодорхойлон гаргасан 4 хэлбэрийн 2 нь уул уурхайн салбарт хамааралтай байдаг ба эдгээр нь:

- боолчлолын бүх хэлбэр болон хүүхдийг худалдах, дамжуулан худалдах, өрийн төлөөс, хамжлагын албат болгох, хүчээр буюу албадан хөдөлмөрлүүлэх, түүний дотор зэвсэгт мөргөлдөөнд ашиглах зорилгоор хүчээр буюу албадан оролцуулах зэрэг боолчлолтой төстэй бүх хэлбэр.
- ажлын шинж чанар, түүнийг гүйцэтгэх нөхцөл нь хүүхдийн эрүүл мэнд, аюулгүй байдал, ёс суртахуунд хор нөлөө үзүүлэх ажил.

ОУХБ-ын 138 дугаар конвенцын нэгэн адил 182 дугаар конвенц нь нэгдэн орсон улс орнууд хүүхдийн эрүүл мэнд, аюулгүй байдал, ёс суртахуунд хор нөлөө үзүүлэх ажилд ямар ажил багтахыг өөрийн дотоодын хууль тогтоомждоо тусгаж байхыг шаарддаг.

4. Хүүхдийн болон албадан хөдөлмөртэй холбоотойгоор ТУУТ (TSM) стандарттай дүйцэхүйц гэж үзэж болох уул уурхайн салбарт хамаарах бусад стандартууд байдаг уу?

Тийм, Олон улсын санхүүгийн корпорацийн (IFC) Гүйцэтгэлийн стандарт эсвэл Хариуцлагатай үнэт чулууны зөвлөлийн (Responsible Jewelry Council) стандарт, шаардлагуудыг хангаж буй нь аудитаар эсвэл баталгаажуулалтаар тогтоогдсон компаниуд нь энэхүү баталгаажуулалтын хүрээнд шаардагдах үйл явцуудыг бүрдүүлэн, үүнийг илтгэн харуулсан хэмээн тооцогдоно. Хариуцлагатай уул уурхайн баталгаажуулалтын санаачилгын (IRMA) хэрэгжүүлдэг хүүхдийн болон албадан хөдөлмөрийн стандартыг мөн ТУУТ (TSM) стандарттай ижил түвшний хэмээн тооцдог ч санаачилгын хийх баталгаажуулалтын үйл явц бүрэн дуусах хүртэл эдгээр нь харилцан хөрвөх эсэхийг албан ёсоор тогтоох боломжгүй.

5. Хүүхдийн болон албадан хөдөлмөрөөс сэргийлэх чиглэлээр ашиглаж болохуйц хэрэгцээтэй хөтөч баримт бичиг байдаг уу?

Хүүхдийн болон албадан хөдөлмөрөөс сэргийлэхтэй холбоотойгоор ашиглаж болох баримт бичгийг доор орууллаа:

1. НҮБ-ын Хүүхдийн сангийн Хөдөлмөрийн нөөцийн хөтөч (UNICEF Child Labour Resource Guide): https://www.unicef.org/csr/css/Child_labour_resource_Guide_UK_NatCom.pdf
2. НҮБ-ын Хүүхдийн сангийн Хүүхдийн эрх болон уул уурхайн салбарын гарын авлага (UNICEF Child Rights and Mining Toolkit): https://www.unicef.org/csr/files/FINAL_Child_Rights_and_Mining_Toolkit_060217.pdf
3. ОУХБ-ын Бизнесүүдэд зориулсан Хүүхдийн хөдөлмөрийн хөтөч гарын авлага- Хүүхдийн хөдөлмөрөөс ангид байх хүүхдийн эрхийг хүндэтгэж хэрхэн бизнес эрхлэх вэ? (ILO Child Labour Guidance Tool for Business - How to do Business with Respect for Children's Right to be Free from Child Labour): http://www.ilo.org/ipecc/Informationresources/WCMS_IPEC_PUB_27555/lang--en/index.htm

Албадан хөдөлмөрөөс сэргийлэх үйл явцыг хэрэгжүүлэхтэй холбоотойгоор ОУХБ нь дараах зааварчилгаа баримт бичгийг гаргасан:

Албадан хөдөлмөртэй тэмцэх нь-Ажил олгогч, бизнес эрхлэгчдэд зориулсан гарын авлага (ILO Combating Forced Labour – A Handbook for Employers & Business): http://www.ilo.org/wcmsp5/groups/public/@ed_norm/@declaration/documents/publication/wcms_101171.pdf

6. ОУХБ-ын Хүүхдийн хөдөлмөрийн тухай конвенц нь Монгол улсын хөдөлмөрийн хуультай хэр хэмжээнд уялддаг вэ?

Хөдөлмөрийн тухайн хуулийн хүүхдийн хөдөлмөр эрхлэлтэй холбоотой заалтыг дор оруулав.

142 дугаар зүйл. Насанд хүрээгүй хүний хөдөлмөр эрхлэлт

- 142.1. 15 насанд хүрээгүй хүнээр энэ хуулийн 142.3, 142.5-д зааснаас бусад тохиолдолд хөдөлмөр эрхлүүлэхийг хориглоно.
- 142.2. Насанд хүрээгүй хүний оюун ухаан, биеийн хөгжил, амь нас, эрүүл мэндэд аюул учруулах, хүмүүжил, ёс суртахуунд сөргөөр нөлөөлөх, хууль тогтоомжоор хориглосон хөдөлмөр эрхлүүлэх, хүүхдийн хөдөлмөрийг мөлжлөгийн хэлбэрээр ашиглах, цалин хөлсийг шударга бусаар тооцож олгох, хүүхдийн нэрээр хууль бус үйл ажиллагаа явуулах зэрэг тэвчишгүй хэлбэрийн хөдөлмөрийг хүүхдээр эрхлүүлэхийг хориглоно.
- 142.3. Хүүхдийн эрүүл мэнд, өсөлт хөгжилд сөрөг нөлөө үзүүлэхгүй, сурч боловсроход саад учруулахгүй нөхцөлд 13-15 насны хүнийг хууль ёсны төлөөлөгч /эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч/-ийн зөвшөөрөлтэйгээр хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлага хангасан ажлын байранд хөнгөн ажил эрхлүүлж болно.
- 142.4. 13 нас хүрсэн хүний эрхэлж болох хөнгөн ажлын төрөл, хөдөлмөр эрхлэлтийн нөхцөлийг хөдөлмөрийн асуудал эрхэлсэн Засгийн

газрын гишүүн тогтооно.

142.5. 15 нас хүрээгүй хүнийг урлаг, спортын үзүүлбэр, зар сурталчилгаанд оролцуулахаар хууль ёсны төлөөлөгч /эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч/-ийн бичгээр, эсхүл тоон гарын үсгээр баталгаажуулсан цахим хэлбэрээр гаргасан зөвшөөрөл, ажиллах цаг, хөдөлмөр эрхлэлтийн нөхцөлийг үндэслэн хүүхдийн эрхийн улсын байцаагч тухай бүр зөвшөөрөл олгосон бол хөдөлмөр эрхлүүлж болно.

/Энэ хэсэгт 2024 оны 01 дүгээр сарын 12-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан./

142.6. Ажил олгогч 18 насанд хүрээгүй хүнээр хөдөлмөр эрхлүүлэх бол хүүхдийн эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, төрсөн он, сар, өдөр, гүйцэтгэх ажил, ажиллах хугацаа, хөдөлмөрийн нөхцөл зэргийн талаар бүртгэл хөтөлж, хөдөлмөрийн болон хөдөлмөрийн хяналтын асуудал хариуцсан тухайн шатны төрийн байгууллагад хөдөлмөр эрхлэлтийн харилцаа үүссэнээс хойш ажлын 10 өдрийн дотор мэдэгдэнэ.

142.7. Ажил олгогч энэ хуульд заасны дагуу 15-18 хүртэлх насны хүнээр хөдөлмөр эрхлүүлэх бол хууль ёсны төлөөлөгч /эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч/ болон тухайн насанд хүрээгүй хүнтэй гуравласан хөдөлмөрийн гэрээ байгуулна.

142.8. Насанд хүрээгүй хүнтэй байгуулах хөдөлмөрийн гэрээнд түүний төрсөн он, сар, өдрийг тусгаж, төрсний гэрчилгээ, эсхүл иргэний үнэмлэхийн хуулбарыг хавсаргана.

142.9. Насанд хүрээгүй хүнийг ажиллуулахыг хориглосон ажлын байрны жагсаалтыг ажил олгогч, ажилтны эрх, хууль ёсны ашиг, сонирхлыг төлөөлөн хамгаалах үндэсний байгууллагын саналыг харгалзан хөдөлмөрийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

143 дугаар зүйл. Насанд хүрээгүй хүний эрүүл мэндийг хамгаалах

143.1. Ажил олгогч насанд хүрээгүй хүнийг ажиллуулах хугацаандаа түүнийг 18 нас хүртэл нь зургаан сар тутам эрүүл мэндийн үзлэгт хамруулна.

143.2. Энэ хуулийн 143.1-д заасан эрүүл мэндийн үзлэгийн зардлыг ажил олгогч хариуцна.

143.3. Урлаг, спортын үзүүлбэр, зар сурталчилгаанд оролцуулахаас бусад тохиолдолд насанд хүрээгүй хүнийг албан томилолтоор ажиллуулахыг хориглоно.

**Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2022 оны 06 дугаар сарын
10-ны өдрийн А/123 дугаар тушаалын хавсралт**

**13 нас хүрсэн хүний эрхэлж болох хөнгөн ажлын төрөл, хөдөлмөр
эрхлэлтийн нөхцөл**

Хүүхдийн оюун ухаан, биеийн хөгжил, амь нас, эрүүл мэндэд аюул учруулах, хүмүүжил, ёс суртахуунд сөргөөр нөлөөлөх болон хууль тогтоомж, насанд хүрээгүй хүнийг ажиллуулахыг хориглосон ажлын байрны жагсаалтад зааснаас бусад төрлийн ажилд 13-15 насны хүнээр хөнгөн ажил эрхлүүлж болно.

13-15 насны хүнээр хөнгөн ажил эрхлүүлэхдээ дараах хөдөлмөр эрхлэлтийн нөхцөлийг хангана:

1. Ажлын цаг:
 - 1.1. Хичээлийн үед долоо хоногт 15 цагаас илүүгүй хугацаагаар буюу долоо хоногт өдөрт 2 цаг, нийтдээ 10 цаг; гэр ахуйн ажилд өдөрт 1 цаг, долоо хоногт нийтдээ 5 цаг хүртэл ажиллуулж болно.
 - 1.2. Хичээлийн улирлын амралтын үед долоо хоногт 20 цагаас илүүгүй хугацаагаар буюу даваагаас баасан гарагт өдөрт 2 цаг эсхүл долоо хоногийн амралтын өдөр 2 цаг; гэр ахуйн ажилд долоо хоногт 8 цаг хүртэл ажиллуулж болно.
2. Хичээлийн болон хичээлийн улирлын амралтаас үл хамааран 13-15 насны хүнийг оройн 18 цагаас өглөөний 06 цагийн хооронд ажиллуулахгүй.
3. Хөнгөн ажил хийх тасралтгүй ажлын цагийн үргэлжлэлийн явцад тогтмол хугацаанд завсарлуулна. Завсарлагын хугацаанд 13-15 насны хүнийг түр амрах, ус уух, бие засах зэрэг нөхцөлөөр хангана.
4. 13-15 насны хүнийг долоо хоногт 5 хүртэл өдөр ажиллуулж болно.
5. 13-15 насны хүнийг хөнгөн ажил эрхлүүлэхдээ хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлага, стандарт хангасан, насны онцлогт тохирсон хөдөлмөрийн нөхцөлөөр хангасан байна.
6. 13-15 насны хүнийг дараах нөхцөлд ажиллуулахгүй:
 - 6.1. насанд хүрсэн хүний байнгын, шууд хяналтгүйгээр ажиллуулах;
 - 6.2. тухайн ажил, үүргийг гүйцэтгэхэд шаардлагатай зохих сургалтад хамруулаагүй;
 - 6.3. гэр бүлээсээ гадуур, нэг өдрөөс дээш удаан хугацаагаар хол байлгах;
 - 6.4. ганцаараа эсхүл олон цагаар тусгаарлагдан ажиллуулах;
 - 6.5. хүүхдийн хүсэл сонирхлыг харгалзан үзээгүй, хүүхэд өөрөө зөвшөөрөөгүй.

**Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2022 оны 06 дугаар сарын
10-ны өдрийн А/122 дугаар тушаалын хавсралт**

**Насанд хүрээгүй хүнийг ажиллуулахыг хориглосон ажлын байрны
жагсаалт**

- 1.1. Хөдөлмөрийн нөхцөл» Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.4-т заасан ажлын байрны болон үйлдвэрлэлийн орчин нөхцөлийг хэлэх бөгөөд хүүхдийн бие, физиологийн хүчин чадлаас хэтэрсэн хүчин чармайлт шаардах, эсхүл хүүхдийн амь нас, бие махбодид аюул учруулах, эсхүл хүүхдийн бие махбод, оюун ухаан, сэтгэлзүйн хөгжилд саад учруулахуйц ажлын хэлбэр, тухайн ажлыг гүйцэтгэх байршил багтана.
- 1.2. Хүүхдийн хөдөлмөрт албадлага, хүч хэрэглэсэнд тооцох нөхцөл:
 - 1.2.1. ажил олгогчийн мэдлийн байранд хорих;
 - 1.2.2. эцэг, эхээсээ хол байрлаж, хоноглож ажиллах нөхцөл үүсгэх;
 - 1.2.3. ажлын байрнаас гадуур бусадтай харилцах боломжгүй байх эсхүл хориглох;
 - 1.2.4. ажил олгогч нь хүүхдийн баримт бичгийг барьцаалж, ажилтанд өгөхгүй байх;
 - 1.2.5. эцэг, эх, харгалзан дэмжигч болон бусад хүмүүсийн өрийн барьцаа, төлөөсөнд ажил олгогчид ажиллах;
 - 1.2.6. ямар нэгэн хариуцлага хүлээлгэхээр айлган сүрдүүлэх;
 - 1.2.7. залилан эсхүл хуурч мэхлэх замаар ажиллуулах.
- 1.3. Хүүхдийн ёс суртахуун, хүмүүжилд сөргөөр нөлөөлөх ажил:
 - 1.3.1. бооцоот уралдаан, интернет мөрийтэй тоглоом зэрэг мөрийцэх, бооцоо тавих бүх төрлийн ажил;
 - 1.3.2. мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодис, тэдгээрийн түүхий эдийг худалдах зэрэг бүх төрлийн хууль бус ажил, үйл ажиллагаа;
 - 1.3.3. эротик үзүүлбэртэй холбоотой ажил эсхүл эротик үзүүлбэр үзүүлдэг газар ажиллах;
 - 1.3.4. согтууруулах ундаа бэлтгэдэг, худалдаалдаг, түүгээр үйлчилдэг ажил;
 - 1.3.5. хууль ёсоор болон хууль бусаар мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодис, тэдгээрийн түүхий эд (үүнд янжуур тамхи багтана) бодис тариалах, хураах, бэлтгэх, худалдаалах, түгээхтэй холбоотой ажил.
- 1.4. Хүүхдийг хүчирхийлэлд өртүүлэх магадлалтай ажил:
 - 1.4.1. гэр бүл, хамт амьдардаг хүмүүсээс нь тусгаарлан, хүүхэд хүчирхийлэлд өртөж байгаа эсэхийг хянах боломжгүй ажил;
 - 1.4.2. харуул хамгаалалт зэрэг зэвсэг хэрэглэх, зөөх, хүч хэрэглэх шаардлага гарах ажил.

- 1.5. Хорт бодист хүүхэд хордох эрсдэлтэй ажил:
 - 1.5.1. хавдар үүсгэгч, үр удамд сөрөг нөлөөтэй, нөхөн үржихүйн эрхтэнг хордуулах эрсдэлтэй ажил;
 - 1.5.2. барилга зэрэг асбест агуулсан материалтай харьцах ажил;
 - 1.5.3. химийн уусгагч, будагч бодис хэрэглэдэг ажил;
 - 1.5.4. удаан задардаг органик (POPs), тогтвортой органик бохирдуулагч (POPs), тодорхой төрлийн песцитит ашиглах ажил;
 - 1.5.5. хар тугалга, мөнгөн ус, хүнцэл, никель, берилли, бусад хортой металл ашиглах ажил;
 - 1.5.6. ажлын байрны химийн сөрөг хүчин зүйлс, хөдөлмөрийн эрүүл ахуйн стандартад заасан зөвшөөрөгдөх дээд хэмжээний 50 хувиас илүү өртөлт бүхий ажил.
- 1.6. Хүүхдийн аюулгүй байдалд аюул учруулах ажил:
 - 1.6.1. газрын түвшнээс 2 метрээс илүү өндөрт дээвэр, тавцан, тагт, цонх, мод зэрэг дээр ажиллах;
 - 1.6.2. цахилгаан, хийгээр ажиллах машин тоног төхөөрөмж (цахилгаан хөрөө, өрөм гэх мэт)-тэй харьцаж ажиллах;
 - 1.6.3. галд шатах, дэлбэрэх аюултай бодистой харьцаж ажиллах;
 - 1.6.4. хязгаарлагдмал орчинд ажиллах (үйлдвэрлэлийн зориулалттай хөргүүр гэх мэт);
 - 1.6.5. цахилгаан үүсгүүр, цахилгаан утастай ажиллах, цахилгаанд цохиулах эрсдэлтэй ажил.
- 1.7. Хүүхдийн эрүүл мэндэд сөрөг нөлөөтэй физикийн хүчин зүйлсэд өртөх эрсдэлтэй ажил:
 - 1.7.1. өндөр хурдтайгаар эргэлдэх болон тууш, долгионт хөдөлгөөн бүхий тоног төхөөрөмж, тухайлбал туузан дамжлага, өрмийн машин дээр гүйцэтгэх зэрэг ажил;
 - 1.7.2. ажлын зааварчилгаа сонсох боломжгүй их дуу чимээтэй ажил;
 - 1.7.3. радиацтай холбоотой ажил;
 - 1.7.4. хэт халуун, хүйтэн цаг агаарын нөхцөлд олон цагаар ажиллах;
 - 1.7.5. ажлын байрны физикийн сөрөг хүчин зүйлс хөдөлмөрийн эрүүл ахуйн стандартад заасан зөвшөөрөгдөх дээд хэмжээний 50 хувиас илүү өртөлт бүхий ажил.
- 1.8. Хүүхдийн эрүүл мэндэд сөрөг нөлөөтэй биологийн аюулд өртөх эрсдэлтэй ажил:
 - 1.8.1. мал амьтны дайралтад өртөх магадлалтай (мал үржүүлгийн үйл ажиллагааны явцад);
 - 1.8.2. өвчтэй мал, шумуул зэрэг амьтдаас зоонозын гаралтай вирус, бактери, паразитын халдвар авах магадлалтай;
 - 1.8.3. үхсэн малын сэг, зэмтэй харьцаж ажиллах;

1.8.4. эмгэгтөрүүлэх нөлөөтэй бактери, вирус зэрэг биологийн аюултай хүчин зүйлсийн нөлөөлөлд өртөх эрсдэлтэй.

1.9. Хүүхдэд эргономикийн аюул үүсгэх ажил:

1.9.1. Өргөх зөөх ачааны зөвшөөрөгдөх дээд хэмжээ:

гараар - 16 нас хүртэлх /эрэгтэй хүүхэд 8 кг, эмэгтэй 5 кг/;

1.9.2. олон давтагдах эсхүл хүчилсэн хөдөлгөөн шаардах ажил

7. Хүүхдийн болон албадан хөдөлмөртэй холбоотойгоор ассоциацийн гишүүн компаниуд нь ханган нийлүүлэлтийн сүлжээндээ хэр хэмжээнд хяналт тавих вэ?

Ханган нийлүүлэлтийн сүлжээнд хүүхдийн болон албадан хөдөлмөр ашиглах эрсдэл багатай¹ улс орнуудаас бараа, үйлчилгээ худалдан авч буй уурхайн хувьд ханган нийлүүлэлтийн сүлжээндээ нэмэлтээр хяналт хийж байх шаардлага тавигдахгүй.

Хүүхдийн болон албадан хөдөлмөрийн эрсдэл өндөр улсаас түүхий эдээ (жишээ нь хайлуулах үйлдвэрт ашиглах баяжмал, эсвэл тээрэмд оруулах хүдэр) худалдан авч буй компанийн хувьд өөрийн ханган нийлүүлэлтийн сүлжээнд багадаа нэгдүгээр түвшнийх нь эрсдэлийг үнэлэх, эрсдэлийг бууруулах арга хэмжээг авч хэрэгжүүлдэг байх ёстой. Магадлан шинжилгээ хийж буйг илтгэн харуулах нэг арга зам нь хүүхдийн болон албадан хөдөлмөртэй холбоотой стандартыг өөрийн үйл явц, гэрээний баримт бичигт уялдуулан тусгаж байх явдал байдаг.

Түүнчлэн уурхайн өөрийн ханган нийлүүлэгчдэд өөрийн сүлжээнийхээ багадаа нэгдүгээр түвшинд хянан магадлагаа хийж байхыг шаардах нь сайн туршлага хэмээн тооцогдоно.

Ханган нийлүүлэлтийн сүлжээнд нь хүүхдийн болон албадан хөдөлмөр ашиглах эрсдэл өндөртэй улсуудад үйл ажиллагаа явуулж буй уурхай нь өөрийн орон нутгаас худалдан авч буй бараан дээр, багадаа сүлжээний нэг түвшинд доош хэмжээнд үнэлгээ хийж байх нь зүйтэй.

8. Эдгээр шаардлагууд нь байгууллагын өөр өөр түвшинд хэрхэн хамаарах вэ? Уурхай (дотоодын, олон улсын), компани?

Протокол нь бусад бүхий л протоколын нэгэн адил уурхайд үндсэндээ чиглэж, тайлагнал нь уурхайн түвшинд явагддаг ч олон тооны компаниуд нь өөрийн компанийн түвшний хяналтыг ашиглан эрсдэлийг удирддаг ба энэхүү хяналтын тогтолцоог хамаарах шалгуурыг хэрэгжүүлж буй нотолгоо болгон ашиглах боломжтой.

¹ НҮБ-ын ХС болон Олон улсын хүүхдийн форум, Хүүхдийн эрх болон бизнесийн атлас (Children's Rights and Business Atlas): <https://www.unicef.org/csr/businessatlas.htm>

9. Протоколын хөдөлмөрийн доод настай холбоотой хэсгийн хэрэгжилтийг баталгаажуулж болох ямар арга аргачлалууд байж болох вэ?

Энэхүү протоколын хэрэгжилтийг баталгаажуулахын тулд компанийн гаргасан бодлого, үүнд дурдсан үүрэг амлалт эсвэл хүний нөөцийн журмуудыг ашиглаж болно. Хүний нөөцийн хэлтэс нь ажиллагсдын насыг шалгахад зориулсан нийт ажилтнуудын бүртгэлтэй байдаг. Баталгаажуулагчид нь энэхүү эх сурвалжийг ашиглаж ажиллагсдын насыг хянан баталгаажуулж болно. Баталгаажуулагчид мөн ярилцлага хийх эсвэл ТУУТ (TSM) стандартын бусад элемент дээр үнэлгээ хийхдээ хамаарах асуултуудыг багтаах замаар протоколын энэхүү хэсгийг баталгаажуулж болно. Баталгаажуулагчид нь уурхай дээр ажиллаж буй бол хүүхдийн хөдөлмөр ашиглаж буй эрсдэл буй эсэх дээр ажиглалт хийж болно.

10. Протоколын албадан хөдөлмөртэй холбоотой хэсгийн хэрэгжилтийг баталгаажуулж болох ямар арга аргачлалууд байж болох вэ?

Энэхүү протоколын хэрэгжилтийг баталгаажуулахын тулд компанийн гаргасан бодлого, үүнд дурдсан үүрэг амлалт эсвэл хүний нөөцийн журмуудыг ашиглаж болно. Хөдөлмөрийн гэрээ эсвэл ажилтанд зориулсан гарын авлага зэрэг нь цалин олгох давтамж болон цалингийн зэрэглэл зэргийг баримтжуулсан байх магадлалтай. Хэрэв баталгаажуулагч нар уурхай дээр ажиллаж буй бол албадан хөдөлмөрийн эрсдэл буй эсэх дээр ажиглалт хийж болно.

11. Хөдөлмөрийн тухай хууль тогтоомж нь сайн, хэрэгжилт нь хангалттай улс орнуудтай харьцуулбал хөгжиж буй орнуудад эдгээр протоколын хэрэгжилтийг баталгаажуулах нь илүү хүндрэлтэй байдаг. Тиймээс албадан хөдөлмөр ашиглаагүй гэдгийг баталгаажуулахын тулд ямар нэмэлт арга хэмжээг авч хэрэгжүүлж болох вэ?

Протоколын хэрэгжилтийг зарим хөгжиж буй оронд шалган баталгаажуулах нь хүндрэлтэй байж болно. ТУУТ (TSM) стандартыг ашиглаж буй компаниуд нь тухайн хамаарах улсад буй эрсдэлтэй нийцэх хэмжээнд өөрийн үйл явцыг хөгжүүлэн бүрдүүлсэн байх шаардлагатай. Баталгаажуулагчдын зүгээс хүүхдийн болон албадан хөдөлмөрийн эрсдэл өндөр улсад ажиллахдаа илүү нарийвчлан судлах нь зүйтэй. Энэ нь тухайн уурхай дээр илүү хүчтэй дотоод үйл явц эсвэл хяналт бүрдсэн байхыг илэрхийлнэ. Харин эрсдэл багатай улсуудад, баталгаажуулагчид нь үйл явц, хяналт эсвэл зохицуулалтын орчинд нь илүү төвлөрч, харин өндөр эрсдэлтэй улсад бол тухайн үйл явцыг хэрхэн хэрэгжүүлж буйг харуулах нотолгоог цуглуулах нь зөв. Баталгаажуулагчид нь тухайн үйл явц эсвэл хяналт бүрдэн бий болсон эсэхийг тодорхойлоход төвлөрч, эдгээрийг хэрэгжүүлж буй эсэхийг тодорхойлоход нотолгоог эрэлхийлэх нь зүйтэй.

ХАВСРАЛТ 2: ТУУТ (TSM) СТАНДАРТЫН БАТАЛГААЖУУЛАЛТЫН ШАЛГАХ ХУУДАС

Хүүхдийн болон албадан хөдөлмөрөөс сэргийлэх

Уурхайн нэр:		Компанийн нэр:	
Үнэлгээ хийсэн:		Хүргүүлсэн огноо:	

Дэмжих баримт бичиг/ Нотолгоо:	
Баримт бичгийн нэр	Байршил

Ярилцлагад хамрагдсан хүмүүс:			
Нэр	Албан тушаал	Нэр	Албан тушаал

АСУУЛТ		Т	Ү	ТАЙЛБАР ба НОТОЛГОО
ҮЗҮҮЛЭЛТ 1: АЛБАДАН ХӨДӨЛМӨРӨӨС СЭРГИЙЛЭХ				
Үзүүлэлт 1	1. Албадан хөдөлмөр, үүнд ялтны хөдөлмөр, ялтны хугацаат хөдөлмөр болон сайн дурын бус хөдөлмөрийг ашиглахгүй байх зорилгоор тухайн улсын хамаарах эрсдэлтэй нийцэх үйл явцыг бүрдүүлсэн байна уу?			
	2. Албадан хөдөлмөрийн эрсдэл өндөр бол ханган нийлүүлэлтийн сүлжээ болон хөдөлмөр зуучлалын харилцаанд хүн худалдаалах болон албадан хөдөлмөр холбогдож буй эсэхийг хянах үйл явцыг бүрдүүлсэн байна уу?			
	Хэрэв бүх асуултад “Тийм” гэж хариулсан бол энэхүү үзүүлэлт дээр “Тийм” гэсэн үнэлгээг сонгоно. Эс бөгөөс “Үгүй” гэсэн үнэлгээг сонгоно.			
ГҮЙЦЭТГЭЛИЙН ҮЗҮҮЛЭЛТ 1 ДЭЭРХ ҮНЭЛГЭЭ		Т / Ү: _____		

АСУУЛТ		Т	Ү	ТАЙЛБАР ба НОТОЛГОО
ҮЗҮҮЛЭЛТ 2: ХҮҮХДИЙН ХӨДӨЛМӨРӨӨС СЭРГИЙЛЭХ				
Үзүүлэлт 2	Дотоодын хууль тогтоомжид заагдсан 18-аас доош насны хүн ажиллах тохиолдолд эрүүл мэнд, аюулгүй байдал болон ёс суртахуунд сөрөг нөлөө үзүүлж болох нөхцөл байдалд хамаарах тухайн улсын эрсдэлтэй хамаарахуйц хэмжээнд 18-аас доош насны хүнийг ажиллуулахаас сэргийлэх үйл явц тогтсон байна уу?			
	15-аас доош насны хүүхдийг ажиллуулдаггүй байх шаардлагыг хангахын тулд эрх зүйн орчны эрсдэлд тохирсон зохицуулалт, процесс хэрэгжиж байгаа юу?			
	Хэрэв бүх асуултад “Тийм” гэж хариулсан бол энэхүү үзүүлэлт дээр “Тийм” гэсэн үнэлгээг сонгоно. Эс бөгөөс “Үгүй” гэсэн үнэлгээг сонгоно.			
ГҮЙЦЭТГЭЛИЙН ҮЗҮҮЛЭЛТ 2 ДЭЭРХ ҮНЭЛГЭЭ		Т / Ү: _____		